183

# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1994 оны 5 сарын 12 өдөр          Дугаар А-89          Улаанбаатар хот

Бөөний барааны зах нээн ажиллуулах тухай

1.Худалдаа-үйлдвэрлэлийн "Хангамж" концернийн хүсэлтийн дагуу гадаадын болон төв, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйлдвэрлэл, техникийн зориулалттай бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бараа материалын бөөнөөр худалдаа хийх нөхцөл, боломжийг сайжруулах, тэднийг гэрээ хэлэлцээр хийх, бараа материал тээвэрлэх хангадахад зуучлах, зах зээлийн мэдээллээр хангах зорилгоор Сонгино хайрхан дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх тус концернийн үүсгэн байгуулагч "Монгол Оюу" компани /УУГазар/-ын эзэмшил газар дээр "Хангамж" концерний "Баян хошуу" зах нээн ажиллуулахыг Сонгино хайрхан дүүргийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч /Н.Дашням/-д зөвшөөрсүгэй.

2."Баян хошуу" захын дүрмийг хавсралт ёсоор батлсугай.

3.Захын захиргаанд ДААЛГАХ нь:

а/Нийслэлийн засаг даргын 1993 оны А/134 тоот захирамжийн 1,2 дугаар заалтыг мөрдлөг болгон ажилласугай.

б/Захын хашааны дотор гадна орчны гудамж талбайд ариун цэвэр, тохижилт, нийгмийн дэг журмыг бүрэн хариуцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА          Ц.БААСАНЖАВ

Нийслэлийн Засаг даргын 1994 оны 4-89 захирамжийн хавсралт

# ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН "ХАНГАМЖ" КОНЦЕРНЫ "БАЯНХУШУУ" ЗАХЫН ДҮРЭМ

## Нэгдүгээр зүйл

### Нийтлэг үндэслэл

1.Барааны худалдаа, зуучлалын "Баянхушуу" зах /цаашид "зах" гэж нэрлэнэ/ нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөгчийн авчирсан үйлдвэрлэл техникийн зориулалттай болон өргөн хэрэглээний барааг хүлээн авч борлуулах, тэднээс дотоодын түүхий эд, бараа зах зээлээс худалдан авахад нь зуучлах орон нутгийн болон нийслэлийн байгууллага иргэдээс өөрсдийн барааг бөөнөөр болон жижиглэн борлуулахад нь зуучлах, бололцоо нөхцөлөөр хангах худалдаа зуучлалын байгууллага мөн.

2.Зах нь худалдаа үйлдвэрлэлийн "Хангамж" концерны харьяаны бие даасан аж ахуйн үйл ажиллагаа явуулах бөгөөд концерны үүсгэн байгуулагч гишүүн байгууллагын хувь нийлүүлсэн худалдааны төвийн хэлбэрээр ажиллана.

3.Захын оноосон нэр: Барааны худалдаа, зуучлалын "Баянхушуу" зах.

4.Захын байрлах газар: Нийслэлийн Сонгино хайрхан дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт Керамик эдлэхүүний комбинат, хязгаарын цэргийн 0119 ангийн хооронд утас факс

## Хоёрдугаар зүйл

### Захын явуулах үйлчилгээний төрлүүд

5.Гадаад, дотоодын байгууллага, иргэд чөлөөтэй худалдаа арилжааг явуулахад туслан, зохих нөхцөлөөр хангах.

6.Тэдгээрийг зах зээл, худалдааны мэдээллээр хангах.

7.Харуул хамгаалалт, агуулах, лангуу, газар талбай, унаа хөсгөөр үйлчлэх.

8.Барааны төрөл бүрийн хяналт, шалгалт/ экспорт импортын барааны чанар, тоо, иж бүрдэл, хорио цээр, ариун цэвэр, эрүүл ахуй, гаалийн/ хийлгэх зөвшөөрөл авахад зуучлан туслах.

9. Зардал, мэдээлэл, сурталчилгаа явуулах.

10. Нийтийн хоолны үйлчилгээ явуулах.

11. Дэлгүүр мухлаг ажиллуулах.

12. Буудлын болон ёслолын үйлчилгээ /удах, угтах, билет суудал унаа захиалах/

13. Тээвэр экспедицийн үйлчилгээ

14. Дүрс бичлэг, гэрэл зураг, ахуйн үйлчилгээ болон цаг-даа, эмнэлэг, касс, банкны хэсэг ажиллуулах үйлчилгээний зууч-лах.

15. Машин техникийн зогсоол, хамгаалалтанд авах үйлчилгээ-нүүдийг үзүүлнэ.

## Гуравдугаар зүйл

## Захын эрх хэмжээ

16. Барааны худалдаа, зуучлалын "Наянхушуу" зах нь гадаад дотоодын байгууллага иргэдийн өөрсдийн барааг борлуулахад худал-даа үйлдвэрлэлийн "Хангамж" концерны нэрийн өмнөөс үйл ажилла-гааг зохицуулан, зуучлах үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

17. Зах нь нийслэлийн засаг даргын шийдвэрийг үндэслэн ху-далдаа үйлдвэрийн "Хангамж" концерны ерөнхий захирлын тушаал гарч Монгол улсын хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүрт-гүүлснээр хуулийн этгээдийн эрхтэй болох ба аж ахуйн бүрэн тоо-цоонд үндсэн дээр бие даасан үйл ажиллагаа явуулна.

18. Зах нь бие даасан өмч хөрөнгөтэй байж түүнийгээ эзэмших, ашиглах, захиран зарцуулах, өөрийн нэрийн өмнөөс гэрээ хэлцэл хийх, шүүхэд нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцох эрхтэй.

19. Зах нь Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд болон энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

20. Зах нь өөрийн бэлгэдэл тэмдэг бүхий бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

## Дөрөвдүгээр зүйл

## Захын эд хөрөнгө, санхүүжилт аж ахуйн үйл ажиллагаа

22. Захын эд хөрөнгө нь Худалдаа үйлдвэрлэлийн "Хангамж" концернаас бүрдүүлсэн хөрөнгө, захын үйл ажиллагааны явцад бий

## Тавдугаар зүйл

### Удирдлага

22.Захын өдөр тутмын үйл ажиллагааг ерөнхий захирлаар толгойлуулсан захиргаа гүйцэтгэнэ.

Ерөнхий захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогчийг худалдаа үйлдвэрлэлийн "Хангамж" концерны ерөнхий захирлын тушаалаар томилно.

23.Ерөнхий захирал дор дурьдсан үүрэг гүйцэтгэнэ.

а/Захыг бусад байгууллага, шүүх болон бусад этгээдийн өмнө төлөөлөх.

б/Захын нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр гэрээ хэлцэл байгуулах, гарын үсэг зурах.

в/Захын хөрөнгийг захиран зарцуулах.

г/Захын ажилтнуудыг томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах, тэдний ажлын хуваарийг тогтоох.

д/Захиргааны орон тоо, цалингийн санг хяналтын тоонд багтаан батлах.

е/Захын үйл ажиллагааг өргөжүүлэх боловсронгуй болгох.

ё/Ерөнхий захирал ажлаа худалдаа үйлдвэрлэлийн "Хангамж" концернад тайлагнана.

ж/Ерөнхий захирал худалдаа үйлдвэрлэлийн "Хангамж" концерноос шийдвэрлэсэн асуудлын хүрээнд тушаал шийдвэр гаргана.

## Зургаадугаар зүйл

### Санхүүгийн тайлан, тооцоо хяналт шалгалт

24.Захын санхүүгийн жил нь тухайн оны I дүгээр сарын I-ний өдрөөс эхлэн /эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс / I2 дугаар сарын 3I-ид /сүүлийн жилийн хувьд бол өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан өдрөөр/ дуусна.

25.Зах нь Монгол улсын албан татварын хууль болон бусад хууль, дүрэм, журмын дагуу хотын төсөвт татвар хураамж төлнө.

26.Зах нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу орлогоосоо хотын төсөвт төлсний дараа нөөцийн болон бусад сангуудыг өөрийн эдийн засгийн чадавхи,онцлогыг харгалзан байгуулна.

27.Захын хөрөнгө мөнгөний зарцуулалт үйл ажиллагаанд хяналт хийх шаардлагатай тохиолдолд Худалдаа үйлдвэрлэлийн "Хангамж" концерн комисс томилж гүйцэтгэнэ.

Долдугаар зүйл

Захын үйл ажиллагааг зогсоох

28.Захыг Худалдаа үйлдвэрлэлийн "Хангамж" концерн нь зохих үндэслэлийг гаргаж татан буулгана.

29.Захыг татан буулгахад Монгол улсын аж ахуйн нэгжийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг зогсоож эцсийн тооцоо хийнэ.